

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

10.17 дугаар зүйлийн 10.17.8 дахь хэсэг:

“10.17.8. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөв тодорхойлоогүй, даатгуулагчийг орхигдуулсан зэргээс баталгаажсан тайланд өөрчлөлт оруулсан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.3 дахь заалтын “тавин” гэсний өмнө “нэг зуун” гэж, “таван” гэсний өмнө “нэг мянган” гэж, 10.17.4 дэх заалтын “бол” гэсний дараа “хүн” гэж, 10.17.5 дахь заалтын “өсгөж” гэсний дараа “шимтгэл төлсөн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.3 дахь заалтын “шимтгэлийг” гэснийг “шимтгэлийн өрийг” гэж, 10.17.5 дахь заалтын “хүнд” гэснийг “хүний” гэж, 10.17.10 дахь заалтын “даатгуулагчийн” гэснийг “даатгуулагч, хүний” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.2 дахь заалтын “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг, 10.17.3 дахь заалтын “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг, 10.17.5 дахь заалтын “нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан” гэснийг, “учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.1, 10.17.6, 10.17.7, 10.17.9, 10.17.11, 10.17.12 дахь заалтуудыг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийгдагаж мөрдөнө.